

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
1. Анхан шатны цахим баримтын талаар .....	9
3.Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
НДШТ	Нийгмийн Даатгалын Шимтгэлийн тайлан
ТҮГ	Төсөвт Үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙ”  
ТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.НАРАНЖАРГАЛ ТАНАА

2020 02.27 № 06/636  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15-р зүйлийн 15.1, 18-р зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.9.1-т заасны дагуу Монголын театрын музей ТҮГ-ын 2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын театрын музей ТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын театрын музей ТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус музейд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Монголын театрын музей” ТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Наранжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үндэслэсэн үйлчлүүлэгчийн худалдан авалт, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Монголын театрын музей” ТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

“Монголын театрын музей” ТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 15-наас 2020 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Голден пэйж аудит ХХК-ийн захирал С.Оюунгэрэл хянан удирдаж, аудитор Я.Оюун, аудиторов туслах Г.Ариун-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монголын театрын музей” ТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Монголын театрын музей” ТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь 2025 он гэхэд Монголын соёл урлаг, 3D үзүүлэгчийн тэргүүлэх чиглэлийн музей болоход оршино.

“Монголын театрын музей” ТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д “Музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 76-р зүйлд “нийтээр амрах баярын өдөр”
- ХХОАТ-ын тухай хуулийн 24-р зүйлд “ албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх”
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15-р зүйд” нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ” гэсэн заалтуудад тус тус өөрчлөлт орсон байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Монголын театрын музей” ТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Монголын театрын музей” ТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

“Монголын театрын музей” ТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар “Монголын театрын музей” ТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд 7 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт 2018 оны санхүүгийн тайлан дахь үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 178,690.0 мянган төгрөгөөс тооцон 3,573.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэж 2019 оны нийт зардал 200,938.1 мянган төгрөгийн 2 хувь болох 4,018.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувиар тооцсон нь тухайн байгууллагын хувьд эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Монголын театрын музей” ТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,372.2 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	128.8		-128,8
Урьдчилгаа			
Бараа материал	16,632.5	7,613,7	-9,018.8
Үндсэн хөрөнгө	833,036.2	828,811.6	-4,224.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>849,797.5</b>	<b>836,425.3</b>	<b>-13,372.2</b>
Өр төлбөр		361.1	361.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	849,797.5	836,064.2	-13,733.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>849,797.5</b>	<b>836,425.3</b>	<b>-13,372.2</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь НДШ, ХХОАТ-ын илүү төлөлтийг тайлант онд тооцоо хийж барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь үйл ажиллагааны зардалд шаардлагатай бараа, бэлэн бүтээгдэхүүн данснаас /Бөмбөгөр ногоон ном, аж ахуйн материал/ зарлагдсанаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ. БСШУСЯ-ны санхүүжилтээр музейн үзмэр 5,750.0 мянган төгрөг, компьютер 759.9 мянган төгрөг, тоос сорогч 270.0 мянган төгрөгөөр худалдан авснаар нийт үндсэн хөрөнгө 6,779.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны бууралт нь тайлант оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Монголын театрын музей” ТҮГ тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч музейн үзвэрийн билет борлуулалтаар 2,875.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн соёл урлагийн хөтөлбөрт зориулан 177,780.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж БСШУСЯ-ны төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 177,633.9 мянган төгрөгийг зарцуулж 146.4 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилт:** Дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилт 6,250.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,874.5 мянга буюу нийт 9,124.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс музейн үзмэр худалдан авахад 5,970.0 мянга, бичиг хэргийн зардал 175.0 мянга, хэвлэлийн зардал 316.5 мянга, тэтгэмжийн зардалд 500.0 мянга, аудитын төлбөрт 1,000.0 мянга, урсгал засварт 807.5 мянга, татварт 280.0 мянган төгрөг буюу нийт 9,049.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 75.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 11,617.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 9,477.0 мянган төгрөгийн 2 асуудлыг анхаарал татах асуудалд оруулж, 2,140.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 2,140.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монголын театрын музей ТҮГ-т 2017 оны аудитаар 6 албан шаардлага, 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж, 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 2 төлбөрийн акт өгч байсан боловч, нягтлан бодогч санхүүгийн тайлангийн үр дүнгийн урамшуулалт цалин авч байгааг анхаарч үзэх, цахим баримтанд шивэгдсэн 8,000.0 мянган төгрөгийн алдаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас хамаарахгүй гарсан тул анхаарал татахуйц асуудалд тусгаж зөвлөмж өгсөн.

Монголын театрын музей ТҮГ-н үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлахгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

“Монголын театрын музей” ТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 9 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,958.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,958.7 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Монголын театрын музей” ТҮГ нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй нийт 11,617.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс 9,477.0 мянган төгрөгийн алдаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас хамаарахгүй гарсан тул анхаарал татахуйц асуудалд тусгаж зөвлөмж өгсөн, 2,140.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 4,018.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Монголын театрын музей” ТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Анхан шатны цахим баримтын талаар**

##### **1.1 Илрүүлэлт-1:**

“Монголын театрын музей” ТҮГ-ийн 2019 оны худалдан авалтыг цахим баримттай тулган шалгахад 8,539.8 мянган төгрөгөөр худалдан авалт илүү илгээгдэн бүртгэсэн нь шилэн дансны гүйлгээнд бүртгэгдээгүй байна. Худалдан авалтын дүнг цахим И баримттай тулган, хянаж бүртгэлийг хөтөлдөггүй байна.

##### **1.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хууль зөрчигдөх эрсдэлтэй.

##### **1.3. Зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах;

##### **1.4. Байгууллагын тайлбар:**

1. Сэлэнгэпресс ХХК нь 2019 онд Улаанбаатар музейн хийлгэсэн 8,000.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээний И баримтыг цахимаар шивэхдээ андуурч шивсэн байна. Залруулгыг тооцоо нийлж хавсаргасан болно.

##### **2.1 Илрүүлэлт-2:**

2019 онд төсөвт зардлын 1,600.7 мянган төгрөгийн гүйлгээ нь анхан шатны цахим “И” баримтгүй хийгдсэн байна.

## **2.2. Эрсдэл:**

НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль зөрчигдөх эрсдэлтэй.

## **2.3. Зөвлөмж**

1. Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх”, 5.1.3-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” 5.1.5-д “ хариуцлагатай байх” гэж заасныг тус тус мөрдөж, дотоод хяналтыг сайжруулах;

## **2.4.Байгууллагын тайлбар:**

1. Харилцагч байгууллагууд цахим И баримт руу илүү дутуу шивсэн.

## **3.Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар**

### **3.1 Илрүүлэлт:**

“Монголын театрын музей” ТҮГ-ийн тайлант онд музейн үзвэрийн орлого бүрдүүлсэн бөгөөд тус орлого нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

### **3.2. Эрсдэл:**

Төсвийн тухай хууль зөрчигдөх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

### **3.3. Зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” 6 дугаар зүйлийн 6.4.1-д “ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэн заалтыг мөрдөж, дотоод хяналтыг сайжруулах; Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах;

### **3.4.Байгууллагын тайлбар:**

Тайлант оны төсөв батлахдаа соёл урлагын байгууллагат орлогыг төлөвлөж, төлөвлөгөө өгөөгүй.

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>16,761,302.68</u></b>	<b><u>7,613,676.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	-
31211	Төрийн сангийн харилцах		-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	128,794.68	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	128,794.68	
3351	Байгууллагаас авах авлага	128,794.68	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	16,632,508.00	7,613,676.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,582,200.00	387,150.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,050,308.00	7,226,526.00
35410	Бичиг хэргийн материал		175,000.00
35420	Аж ахуйн материал	2,613,108.00	2,847,941.00
35470	Бусад хангамжийн материал	1,437,200.00	4,203,585.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>833,036,191.90</u></b>	<b><u>828,811,633.90</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	833,036,191.90	828,811,633.90
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	832,557,252.02	828,401,114.06
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,725,423.00	23,485,403.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	7,581,725.00	11,467,972.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,177,018.73	61,177,018.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	31,266,854.45	36,113,479.49
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	779,669,020.00	785,419,020.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,608,873.75	25,878,863.75
39215	Хуримтлагдсан элэгдэл	19,284,504.01	21,487,739.83
39217	Ном	1,510,000.00	1,510,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	478,939.88	410,519.84
39301	Програм хангамж	684,200.00	684,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	205,260.12	273,680.16
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>849,797,494.58</u></b>	<b><u>836,425,309.90</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>361,050.32</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	361,050.32
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	361,050.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	361,050.32

41361	Байгууллагад төлөх өглөг		361,050.32
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>849,797,494.58</u></b>	<b><u>836,064,259.58</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	849,797,494.58	836,064,259.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	70,433,859.73	70,433,859.73
51101	Өмч: - төрийн	70,433,859.73	70,433,859.73
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	58,643,701.85	44,910,466.85
51210	Өмнөх үеийн үр дүн	41,878,529.82	58,643,701.85
51220	Тайлант үеийн үр дүн	16,765,172.03	(13,733,235.00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	720,719,933.00	720,719,933.00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>849,797,494.58</u></b>	<b><u>836,425,309.90</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>195,453,900.00</b>	<b>187,204,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,543,400.00</b>	<b>300,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,543,400.00	300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,681,400.00	300,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,203,500.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,477,900.00	300,000.00
120009	Бусад орлого	862,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>180,910,500.00</b>	<b>186,904,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	159,410,500.00	177,780,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	159,410,500.00	177,780,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,500,000.00	9,124,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,500,000.00	6,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,874,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>178,688,727.97</b>	<b>200,938,135.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>178,688,727.97</b>	<b>200,938,135.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	178,190,089.23	199,216,228.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	106,208,799.00	111,396,227.57
210101	Үндсэн цалин	79,464,299.00	96,128,027.57
210102	Нэмэгдэл	14,144,500.00	8,968,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600,000.00	6,300,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,160,667.78	14,877,646.00
210201	Тэтгэврийн даатгал	9,192,267.78	10,421,046.00
210202	Тэтгэмжийн даатгал	992,200.00	1,114,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	793,200.00	891,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	198,500.00	222,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,984,500.00	2,228,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,978,600.00	30,978,600.00
210304	Байрны түрээс	30,978,600.00	30,978,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,858,099.80	17,970,827.32

210401	Бичиг хэрэг	2,511,110.00	894,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	977,139.80	838,465.32
210404	Ном, хэвлэл	129,800.00	14,145,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,500.00	451,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,789,550.00	1,641,812.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,777,300.00</b>	<b>1,663,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	338,800.00	-
210602	Тавилга	480,700.00	55,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,957,800.00	1,608,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>800,000.00</b>	<b>800,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	800,000.00	800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,436,200.00</b>	<b>10,025,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,436,200.00	6,528,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	3,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		497,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,970,422.65</b>	<b>11,504,528.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,470,422.65	11,004,528.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>498,638.74</b>	<b>1,721,906.11</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>498,638.74</b>	<b>221,906.11</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	498,638.74	221,906.11
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>16,765,172.03</u></b>	<b><u>(13,733,235.00)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>16,765,172.03</u></b>	<b><u>(13,733,235.00)</u></b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>183,114,000.00</b>	<b>186,904,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,203,500.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,203,500.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,203,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,203,500.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>180,910,500.00</b>	<b>186,904,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	159,410,500.00	177,780,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	159,410,500.00	177,780,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,500,000.00	9,124,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,500,000.00	6,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,874,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>181,614,000.00</b>	<b>180,124,930.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>181,614,000.00</b>	<b>180,124,930.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>181,115,361.26</b>	<b>178,403,023.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	106,706,461.46	111,357,228.57
210101	Үндсэн цалин	79,961,961.46	80,821,028.57
210102	Нэмэгдэл	14,144,500.00	17,936,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600,000.00	12,600,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,791,800.00	14,426,800.00
210201	Тэтгэврийн даатгал	8,822,800.00	9,970,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	992,200.00	1,114,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	793,800.00	891,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	198,500.00	222,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,984,500.00	2,228,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,978,600.00	30,978,600.00
210304	Байрны түрээс	30,978,600.00	30,978,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,656,499.80	5,528,465.32
210401	Бичиг хэрэг	1,974,760.00	892,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	977,139.80	838,465.32
210404	Ном, хэвлэл	12,000,000.00	1,816,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,500.00	451,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,254,100.00	1,530,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,305,800.00	3,578,030.00



210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	889,185.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	3,305,800.00	1,688,845.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	800,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,376,200.00	10,733,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,876,200.00	6,736,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	3,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	497,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	500,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>498,638.74</b>	<b>1,721,906.11</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	498,638.74	221,906.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	498,638.74	221,906.11
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,500,000.00</u></b>	<b><u>6,779,970.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,500,000.00</b>	<b>6,779,970.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,500,000.00</b>	<b>6,779,970.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,500,000.00	6,779,970.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	6,779,970.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,500,000.00)</u></b>	<b><u>(6,779,970.00)</u></b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	70,433,859.73	720,719,933.00	21,428,529.82	812,582,322.55
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	20,450,000.00	20,450,000.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>70,433,859.73</b>	<b>720,719,933.00</b>	<b>41,878,529.82</b>	<b>833,032,322.55</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	16,765,172.03	16,765,172.03
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>70,433,859.73</b>	<b>720,719,933.00</b>	<b>58,643,701.85</b>	<b>849,797,494.58</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>70,433,859.73</b>	<b>720,719,933.00</b>	<b>58,643,701.85</b>	<b>849,797,494.58</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-13,733,235.00	-13,733,235.00
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>70,433,859.73</b>	<b>720,719,933.00</b>	<b>44,910,466.85</b>	<b>836,064,259.58</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	177,780,400.00	177,633,993.89	146,406.11	99.9
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	177,780,400.00	177,633,993.89	146,406.11	99.9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	176,780,400.00	176,633,993.89	146,406.11	99.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	111,414,700.00	111,357,228.57	57,471.43	99.9
210101	Үндсэн цалин	80,878,500.00	80,821,028.57	57,471.43	99.9
210102	Нэмэгдэл	17,936,200.00	17,936,200.00	-	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600,000.00	12,600,000.00	-	100
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,426,800.00	14,426,800.00	-	100
210201	Тэтгэврийн даатгал	9,970,200.00	9,970,200.00	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	1,114,200.00	1,114,200.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	891,300.00	891,300.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	222,800.00	222,800.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	2,228,300.00	2,228,300.00	-	100
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,978,600.00	30,978,600.00	-	100
210304	Байрны түрээс	30,978,600.00	30,978,600.00	-	100
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,056,500.00	5,036,965.32	19,534.68	99.6
210401	Бичиг хэрэг	505,500.00	717,500.00	(212,000.00)	142
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,500.00	838,465.32	662,034.68	55.9
210404	Ном, хэвлэл	1,500,000.00	1,500,000.00	-	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,500.00	451,000.00	(500.00)	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	1,530,000.00	(430,000.00)	139
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,800,500.00	3,800,500.00	-	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	1,919,155.00	80,845.00	96
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00	-	100
210604	Урсгал засвар	800,500.00	881,345.00	(80,845.00)	110.1
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	800,000.00	800,000.00	-	100

210702	Дотоод албан томилолт	800,000.00	800,000.00	-	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,303,300.00	9,233,900.00	69,400.00	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,263,300.00	6,236,900.00	26,400.00	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	497,000.00	3,000.00	99.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,000.00		40,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	500,000.00	-	100
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,000,000.00	1,000,000.00	-	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00	-	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00	-	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,000,000.00	1,000,000.00	-	100
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	1,000,000.00	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	177,780,400.00	177,633,993.89	146,406.11	99.9
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	177,780,400.00	177,633,993.89	146,406.11	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	177,780,400.00	177,633,993.89	146,406.11	99.9

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	<b>9,124,000</b>
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	<b>9,124,000</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	-	<b>8,549,000</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	-	<b>491,500</b>
210401	Бичиг хэрэг	-	175,000
210404	Ном, хэвлэл	-	316,500
2106	Эд хогшил худалдан авах	-	<b>807,500</b>
210604	Урсгал засвар	-	807,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	1,000,000
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	1,000,000
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	575,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	500,000
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	75,500
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	75,500
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>9,049,000</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,049,000
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,250,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,799,000

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2020.02.17</b>	Аудитын нэр: <b>Монголын театрын музей ТҮГ 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн</b>	Аудитын код: <b>САГ-2020/455/СТА-</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Монголын театрын музей ТҮГ</b>	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цахим баримт бүрдүүлэлт	539.80	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Наранжаргал, Ч.Очмандах
2	Цахим баримт бүрдүүлэлт дутуу	1,600.70	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Наранжаргал, Ч.Очмандах
3	Орлогыг төлөвлөдөггүй байна.		Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Наранжаргал, Ч.Очмандах
4	Дүн	2,140.5			



